ДОРНОД АЙМАГ
БАЯНТҮМЭН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 08 сарын 05 өдөр Дугаар 13/05 Цагаан дэрс

Малын жишиг үнэ шинэчлэн тогтоон батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Тус сумын нутаг дэвсгэрт дагаж мөрдөх малын жишиг үнэ болон нөхөн төлбөрийн үнийг хавсралтаар баталсугай.

2.Тогтоолыг хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын Засаг дарга (П.Гунгаацэрэн)-д даалгасугай.

3.Энэхүү тогтоол баталсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА Ж.БАТЧУЛУУН

Баянтүмэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2026 оны 08 дугаар сарын 05-ны
өдрийн 13/05 дугаар тогтоолын хавсралт

МАЛЫН ЖИШИГ ҮНЭ

/ Мян.төг/

Малын төрөл	Малын хүйс	Жишиг үнэ	Нөхөн төлбөрийн үнэ
Тэмээ	Ботго	800.000	720.000
	2 наст	1.000.000	900.000
	3 наст	1,200.000	1.080.000
	4 наст	1.500.000	1.350.000
	Ингэ	2,000.000	1.800.000
	Ат	2.500.000	2.250.000
	Буур	3.000.000	2.700.000
Адуу	Унага	800.000	720.000
	Даага	1.300.000	1.170.000
	Шүдлэн	1.500.000	1.350.000
	Хязаалан	1.700.000	1.530.000
	Соёолон	2.000.000	1.800.000
	Гүү	2.300.000	2.070.000
	Морь	2.500.000	2.250.000
	Азарга	3.000.000	2.700.000
Үхэр	Тугал	800.000	720.000
	Бяруу	1.500.000	1.350.000
	Шүдлэн	3.600.000	3.240.000
	Хязаалан	5.500.000	4.950.000
	Соёолон	6.800.000	6.120.000
	Үнээ	4.500.000	4.050.000
	Эр үхэр	7.000.000	6.300.000
	Бух	5.500.000	4.950.000
Хонь	Хурга	150.000	135.000
	Төлөг	400.000	360.000
	Эм хонь	550.000	495.000
	Эр хонь	600.000	540.000
	Хуц	500.000	450.000
Ямаа	Ишиг	120.000	108.000
	Борлон	200.000	180.000
	Эм ямаа	300.000	270.000
	Эр ямаа	350.000	315.000
	Ухна	400.000	360.000